



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/243

Баян-Өндөр сум

Г Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад Г
дэмжлэг үзүүлэх зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Ээлжит XIII хуралдааны 13/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2. Зөвлөлийн үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн дарга (А.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын "Журам баталж, зөвлөл байгуулах тухай" 2017 оны А/628 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ



Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 11-ны өдрийн
1/24/23...дугаар захирамжийн I хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛТНУУДАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: А.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд: С.Мөнхзул (Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, сургалт хариуцсан мэргэжилтэн)
- А.Отгон (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн Албаны дарга)
- С.Гүнчинсүрэн (Хувийн хэвшлийн Чандмань Эрдэнэ холбооны тэргүүн)
- Б.Жаргалсайхан (Өрхийн анагаах ухааны мэргэжилтний холбооны тэргүүн)
- А.Шинэбаяр (Эрдэнэт сувилал цогцолборын хүний нөөцийн менежер)

Нарийн бичгийн дарга О.Батцэнгэл (Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн)

00

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын // -ны өдрийн
А/243 дугаар захирамжийн II хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛТНУУДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2,11.1.5, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит II хуралдааны 02/02 дугаарт тогтоолоор баталсан "Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан "Эмч" хөтөлбөрийн 5.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн, эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, эм зүйч, эм найруулагч, эмнэлгийн ажилтнуудад дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2.Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт, холбогдох баримт бичгүүдийг үндэслэн эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөлийн (цаашид "зөвлөл" гэх) хурлын шийдвэрээр журамд зааснаар дэмжлэг үзүүлнэ.

1.3.Урт, богино хугацааны сургалтад хамрагдан мэдлэг боловсролоо дээшлүүлэх, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийлгэх, орон сууцны дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн чиглэлээр ном хэвлүүлэх, байгалийн гамшиг зэрэг дэмжлэгийг **нийгмийн дэмжлэг** гэж ойлгоно.

1.4.Дэмжлэг авсан ажилтнууд олгосон дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.

Хоёр.Нийгмийн дэмжлэгийн хамрах хүрээ, нөхцөл

2.1.Нийгмийн дэмжлэгийн хамрах хүрээ

2.1.1.Орхон аймгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудад хамаарна.

2.1.2.Дэмжлэг хүсэгчдэд тавигдах шаардлага

а.Тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх
б.Цаашид тогтвор суурьшилтай ажиллах /Тухайн байгууллагын тодорхойлолтыг баримтлах/

в.Дэмжлэгтэй холбогдох баримтыг бүрдүүлсэн байх

г.Татварт бүртгэлтэй данстай байх

2.2.Нийгмийн дэмжлэгийн төрөл, зориулалт, хэмжээ

2.2.1.Нийгмийн дэмжлэгийг эрүүл мэндийн салбарын ажилтнуудад хөтөлбөрийн хугацаанд зөвхөн 1 удаа давхцуулахгүй олгоно.

2.2.2.Дотоод сургалтын дэмжлэг нь 1,000,000 төгрөг хүртэл байна.

2.2.3.Гадаад сургалтын дэмжлэг нь 5,000,000 төгрөг хүртэл байна

2.2.4.Эрүүл мэндийн шинжилгээ, оношилгоо хийлгэхэд 1,000.000 төгрөг хүртэл, мэргэжлийн чиглэлээр ном хэвлүүлэхэд 1,000,000 төгрөг хүртэл тус бүр хэтрэхгүй байна.

2.2.5.Амь насанд аюултай, хүнд өвчний улмаас мэс засал оношилгоо эмчилгээ хийлгэх, хүнд өвчний улмаас гадаад оронд зайлшгүй шаардлагаар эмчлүүлэхэд 8,000.000 төгрөг хүртэл

2.2.6.Байгалийн гамшигт өртсөн үед үзүүлэх дэмжлэг 5,000,000 төгрөг хүртэл

2.3.Нийгмийн дэмжлэгийг олгох үйл ажиллагаа

2.3.1.Сургалтын дэмжлэг хүсэгч дараах материалыг бүрдүүлнэ.

а.Сургалтын дэмжлэг хүссэн өргөдөл (Маягт №1)

б.Иргэний цахим үнэмлэхийн хуулбар

в.Суралцах байгууллагаас суралцахыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл, сургалтын төлбөрийн нэхэмжлэх, төлбөрийн И –баримт

г. Байгууллагын тодорхойлолт

2.3.2.Бусад төрлийн дэмжлэг хүсэгч дараах материалыг бүрдүүлнэ.

а.Нийгмийн дэмжлэг хүссэн өргөдөл (Маягт №2)

б.Иргэний цахим үнэмлэхийн хуулбар

в.Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалтад орсон өвчин болохыг нотолсон Эмнэлэг хяналтын комиссын өвчний заалтыг тусгасан шийдвэрийн маягт, байгалийн гамшигт өртсөнийг батлах баримт, онцгой байдлын газрын дүгнэлт, мэргэжлийн чиглэлээр ном хэвлүүлэх эх загвар зэрэг материалыг өөрийн шийдвэрлүүлэх асуудлын хүрээнд бүрдүүлнэ.

2.4.Өөрийн хүсэлтээр гадаад улсад эмчлүүлэхээр гаргасан өргөдөл энэ журамд хамаарагдахгүй.

2.5.Нийгмийн дэмжлэг олгох тухай шийдвэр гаргах, олгох үйл явц

2.5.1.Зөвлөлийн ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна.

Зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хурлыг зарлан хуралдуулж болно.

2.5.2.Зөвлөлийн хурлыг гишүүдийн 78 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.5.3.Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.

2.5.4.Зөвлөл нь нийгмийн дэмжлэг хүссэн материалтай танилцан тавигдах шаардлага, шалгуурын дагуу үнэлэлт, дүгнэлт өгч, асуудлыг зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргах ба шийдвэрийг хуралдааны тэмдэглэлээр албажуулна.

2.5.5.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хуралдаанд саналын эрхтэйгээр оролцоно.

2.5.6.Зөвлөл нь нийгмийн дэмжлэг олгосон шийдвэрийг байгууллагын архивд хадгалуулна. Хувийн хэрэгт дараах баримт бичгийг дор дурдсан дарааллаар хавсаргана.

а.Нийгмийн дэмжлэг олгосон захирамж

б.Дэмжлэг авсан ажилтнуудын дансны дугаар бүхий мөнгө шилжүүлсэн баримт

в.Нийгмийн дэмжлэг олгоход бүрдүүлсэн баримт бичгүүд

2.6.Бусад нөхцөл

2.6.1.Дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулахыг хатуу хориглоно.

2.6.2.Зөвлөл нь үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргад танилцуулж байна.

2.6.3.Зөвлөлийн гишүүд дараах үндсэн зарчмыг мөрдөн ажиллана.

а.Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, шударга ёс хүлээсэн үүрэгтэй үнэнч байж, ажлаа бүрэн хариуцах

б.Нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчил бусдын нөлөөнд автахгүй, ялгаварлахгүй, хүнд суртал гаргахгүй, чирэгдүүлэхгүй, өөрийн садан төрөл, танил талд давуу байдал олгож үйлчлэхгүй байх

в.Байгууллага, хувь хүний нууцыг чандлан хадгалах

2.6.4.Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг дэмжлэгт зарцуулах батлагдсан төсвөөс шийдвэрлэнэ. Энэ нь батлагдсан төсвийн 2 хувиас хэтрэхгүй байна.

2.6.5.Дэмжлэгийг хууль бусаар зарцуулсан тохиолдолд олгосон санхүүжилтийг 100 хувь буцаан бүрэн төлж барагдуулна.

СУРГАЛТЫН ДЭМЖЛЭГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

1.Ерөнхий мэдээлэл /сургалтын дэмжлэг хүсэгч өөрийн гараар цэвэр, гаргацтай бөглөнө./

1.1.Нэр:

/Овог, нэрийг бүтэн бичнэ/

1.2.Регистрийн дугаар:

1.3.Ажил, албан тушаал:

1.4.Гэрийн хаяг:

1.5.Холбоо барих утас:

1.6.Зайлшгүй тохиолдолд холбоо барих утас, таны юу болох

.....

2.Сургалтын дэмжлэгийн талаар: / Сургалтын дэмжлэг хүсэгч өөрийн гараар цэвэр, гаргацтай бөглөнө./

Сургалтын дэмжлэгийн зориулалт: „Дотоод, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалт нь улс, бүс, /доогуур зур/ -д сургууль, байгууллагад 20... оныр сарын өдрөөс өдөр хүртэл хоногийн сургалтад чиглэлээр суралцана.

3.Дэмжлэгийн хэмжээ /төгрөгөөр/

/ үсгээр бичнэ /

/ Гарын үсэг, он,сар, өдөр//

ДЭМЖЛЭГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

1.Ерөнхий мэдээлэл /дэмжлэг хүсэгч өөрийн гараар цэвэр, гаргацтай бөглөнө./

1.1.Нэр:/Овог, нэрийг бүтэн бичнэ/

1.2.Регистрийн дугаар:

1.3.Ажил, албан тушаал:

1.4.Гэрийн хаяг:

1.5.Холбоо барих утас:

1.6.Зайлшгүй тохиолдолд холбоо барих утас, таны юу болох

2.Дэмжлэгийн талаар: /Хамаарах чиглэлийн доогуур зурах/

2.1.Дэмжлэгийн зориулалт: тодорхой хэрэгцээ шаардлагын улмаас

-Эрүүл мэндийн шинжилгээ, оношилгоо хийлгэх

-Амь насанд аюултай, хүнд өвчний улмаас мэс засал оношилгоо

эмчилгээ хийлгэх, хүнд өвчний улмаас гадаад оронд зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх

-Байгалийн гамшигт өртсөн

-Мэргэжлийн чиглэлээр ном хэвлүүлэх

2.2.Дэмжлэгийн хэмжээ /төгрөгөөр/

2.3..... /үсгээр/

/ Гарын үсэг, он, сар, өдөр /